

ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛЖ, БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТЕНДЕРИЙН САНАЛ ИРҮҮЛЭХИЙН ӨМНӨХ УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Монголын Мянганы сорилтын сан Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагааны хүрээнд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн зураг төсөл боловсруулж, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх олон улсын тендер шалгаруулалтыг 2021 оны 07-дугаар сарын 26 -ны өдөр зарласан билээ. Энэ ажлын хүрээнд Тендерийн санал ирүүлэхийн өмнөх уулзалтыг 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр цахимаар зохион байгууллаа. Уулзалтад гадаад, дотоодын 24 компанийн төлөөлөл оролцож дэлгэрэнгүй мэдээлэл

авав.

[Эх сурвалж: Монголын Мянганы сорилтын сангийн цахим хуудас](#)

ШИНЭ ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН БИОРЕАКТОРЫН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ 40%-ТАЙ БАЙНА



Монгол Улсын Засгийн газраас “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн талаар авах арга хэмжээний тухай” 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 311 тоот тогтоол гарч, “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийг баталж, төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг БНХАУ-ын Засгийн газраас Монгол улсын Засгийн газарт олгох /1.0/ нэг тэрбум ам.долларын зээлийн хүрээнд батлагдсан техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу барьж байгуулахаар шийдвэрлэсэн. Төслийн барилга угсралтын ажлын хөрс хуулалт, суурийн газар шорооны ажлыг 2019 оны намар эхлүүлж, 2020 оны 8 дугаар сард үндсэн байгууламжийн ажлыг эхлүүлсэн. Одоогоор “А” болон “Б”

биореакторын барилга угсралтын ажил 40%-тай, хоёрдугаар тунгаагуур, лаг өтгөрүүлэгч, захиргаа болон зам гүүрний барилгын ажлуудыг эхлүүлээд байна. Нийт төслийн барилга угсралтын ажлын явц 28%-тай байна. Төслийн талбайд гадаадын 50 ажилчин, монгол талын 450 инженер техникийн ажилчид ажиллаж байна.

[Эх сурвалж: Барилга хот байгуулалтын яамны цахим хуудас](#)

БАГАНУУР ДҮҮРГИЙН УС ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТАЛБАЙН ГАЗРЫН ДООРХ УСНЫ ОРДОД АШИГЛАЛТЫН ХАЙГУУЛ СУДАЛГАА ХИЙЖ ЭХЭЛЖЭЭ



Анх 1974 онд ЗХУ-ын ПНИИИС-ын байгууллага хайгуулын ажил гүйцэтгэж 1977 оноос өдийг хүртэл 44 жил тасралтгүй ашиглаж байгаа тус ордод энэ жил анх удаа ашиглалтын хайгуул судалгааны ажлыг Нийслэлийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар "Карст" ХХК гүйцэтгэж байна. Хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэснээр ордын нөөцийг шинэчлэн тогтоож, эх үүсвэрийн цаашдын төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах зөвлөмжийг өгч, эх үүсвэрийн хориглолт, хязгаарлалтын бүсийг шинэчлэх, газрын доорх усны ашиглалтын цооногуудыг байгуулж усны түвшний бууралтад тогтмол хяналт тавих, дүүргийн хүн амыг эрүүл, аюулгүй, баталгаат усаар хангах нөхцөл бүрдэх юм.

[Эх сурвалж: Хэрлэн голын сав газрын захиргааны фэйсбүүк хуудас](#)

ХЭНТИЙ АЙМАГ ОРЧИН ҮЕИЙН БОХИР УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖТАЙ БОЛЛОО



Хэнтий аймгийн Чингис хаан хотын Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил дууслаа. 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдөр Улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулжээ. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд есөн аймгийн Цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, барих ажил хийгдэж байгаа юм.

[Эх сурвалж: www.news.mn](http://www.news.mn)